



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 17

Номгон

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
дэргэдэх орон тооны бус Залуучуудын зөвлөлийн
бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх орон тооны бус Залуучуудын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг орон тооны бус Залуучуудын зөвлөлийн дарга /Б.Наранбаяр/-д үүрэг болгосугай.

3. Зөвлөлийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, төсөв, санхүүгийн шийдвэрлэж, үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулж тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА


Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0117146




Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний
өдрийн 17 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДЭРГЭДЭХ ОРОН ТООНЫ БУС ЗАЛУУЧУУДЫН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог	Нэр	Он	Харьяалал	Дугаар	Цахим хаяг
1	Амаржаргал	Өлзийжаргал	1987	3	99017464	a.ulziijargal@gmail.com
2	Батменх	Наранбаяр	1987	3	89400505	bhchamber_nb@yahoo.com
3	Батменх	Цэрэнжаргал	1993	3	95991899	tseegii.0506@yahoo.com
4	Энхболд	Мөнх-эрдэнэ	1997	6	88954359	
5	Сэргэлэн	Энхбаяр	1988	6	99196335	enkhee_ktms@yahoo.com
6	Батнасан	Очирсүрэн	1992	4	88780244	
7	Ганболд	Ганчулуун	1987	1	91946161	gaanjii@yahoo.com
8	Тунгалаг	Өлзийдэлгэр	1990	1	88009328	ulziimgl2@gmail.com
9	Бат-өлзий	Даваасүрэн	1994	1	88153992	davka_513@yahoo.com
10	Эрдэнэбат	Биндэрьяа	1997	4	88950773	ebinderiya@yahoo.com
11	Далай	Оюунзаяа	1989	1	88058600	oyukastar_999@yahoo.com
12	Ажиршгүй	Сайханцэцэг	1986	2	88099226	saihnaa_itgel0205@yahoo.com
13	Занабазар	Дуламсүрэн	1990	5	99132585	duuya_0226@yahoo.com
14	Цэвээндорж	Азбаясгалан	1992	5	99011659	
15	Сангишар	Лхамхорол	1987	1	89880408	lhamaas24@gmail.com
16	Сайнбаяр	Буянжаргал	1990	1	80011005	Buya.hey@yahoo.com
17	Амгалан	Ариунзаяа	1995	1	86563003	
18	Хүрэлчулуун	Баасандорж	1991	Баянлиг	95090946	baaska0405yahoo.com
19	Ганбат	Нямдаваа	1994	Өлзийт	94515181	g.nyamdavaa@yahoo.com
20	Шаравсэнгэ	Бямба-Өлзий	1992	Гурванбулаг	80807087	ulzii808028@gmail.com
21	Бэгзсүрэн	Мөнхтуул	1985	Эрдэнэцогт	88208299	tuul_8299@yahoo.com

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний
өдрийн 17 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ ОРОН ТООНЫ БУС ЗАЛУУЧУУДЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 135 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд байгуулагдах залуучуудын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус залуучуудын зөвлөл /цаашид “Залуучуудын зөвлөл” гэх/-ийн ажиллах журмыг үүгээр тодорхойлно.

1.2 Залуучуудын зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, тэдгээртэй холбогдох бусад хууль, тогтоомжууд болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН ЗОРИЛГО, ЗАРЧИМ

2.1. Баянхонгор аймгийн Залуучуудын зөвлөл нь орон нутгийн залуучуудын онцлогт тохирсон хөгжлийн бодлого хөтөлбөр боловсруулах, ээлтэй төсвийн хэмжээг нэмэгдүүлэх, залуучуудын дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх, залуучуудын чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, төрийн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, хяналт тавихад чиглэнэ.

2.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг удирдлага болгоно.

2.1.1 Ардчилсан ёс, шударга ёс, хүний эрхийн зарчимд тулгуурлах;

2.1.2 Залуучуудын оролцоог хангаж, харилцан хүндэтгэх;

2.1.3 Зөвлөл нь орон тооны бус, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн, нэгдмэл байдлаар хамтран ажиллах

2.1.4 Салбарын асуудалд шударга, тэгш байдлыг хангах;

2.1.5 Хамтын ажиллагаанд зөвлөлийн гишүүн нь бусад байгууллагын бие даасан байдал, тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй харилцах;

2.1.6 Ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод байдлыг хангах.

2.1.7 Зөвлөл нь улс төр, шашны үйл ажиллагаанаас ангид байна.

ГУРАВ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Ажлын алба нь Залуучуудын зөвлөл оролцох шаардлагатай хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг залуучуудын зөвлөлд хурал хуралдахаас 3 хоногийн өмнө хүргэх

3.2 Хурлын хуралдаанаас гарсан тогтоол шийдвэртэй Залуучуудын зөвлөлийн гишүүдийг танилцах боломжоор хангах

3.3 Үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх байр танхим, шаардлагатай техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх

3.4 Залуучуудын зөвлөлийн хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэн жил бүрийн төсөвт санхүүгийн эх үүсвэрийг тусгаж байх

3.5 Залуучуудын зөвлөлийн төлөөллийг залуучуудын асуудлыг хэлэлцэх үед тэргүүлэгчдийн хуралдаанд оролцуулж байх

ДӨРӨВ. ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Зөвлөл нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын эрхлэх асуудлын хүрээнд залуучуудын хөгжилтэй холбогдох бодлого боловсруулах, төлөвлөлт хийх үйл явцад санал дэвшүүлэх, зөвлөх, хянах, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.2 Зөвлөл нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны үйл ажиллагаанд залуучуудын нийтлэг эрх ашгийг тусгуулахад идэвхтэй оролцоно.

4.3 Залуучуудын эрх, үүрэг, хөгжил, оролцоог хангахтай холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэж, зөвлөмж гаргах

4.4 Өсвөр үе, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх

4.5 Залуучуудын хөгжлийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, санал, дүгнэлт гаргах

4.6 Залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийсэн, идэвх санаачилга гарган нийгэмд манлайлал үзүүлсэн хуулийн этгээд, иргэдийг алдаршуулах

4.7 Залуучуудын зөвлөл нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн болон хурлын хуралдаанд төлөөллөө оролцуулах эрхтэй

ТАВ. ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН БОЛОН ДЭМЖИГЧ ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

5.1.1. Залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар санал, санаачилга гаргаж зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтийг дэмжин ажиллах

5.1.2 Тухайн салбарын бодлого, хөтөлбөрт залуучуудын хөгжил, хамгаалал, аж байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээ тусгуулж хэрэгжилтэд оролцох

5.1.3 Зөвлөлийн хуралдаанд тогтмол оролцож, хэлэлцэх асуудлаар санал гаргах

5.1.4 Зөвлөлийн гишүүд харилцан мэдээлэл солилцох, цуглуулах, түгээхэд хамтран ажиллана.

5.1.5 Зөвлөлийн гишүүд холбоо барих хаяг, утас, и-мэйл хаягаа өөрчлөх бүрдээ зөвлөлийн нарийн бичгийн даргад мэдэгдэж байна.

5.2 Залуучуудын зөвлөлийн дэмжигч гишүүн дараах эрх үүрэгтэй.

5.2.1 Зөвлөлд арга зүйн болон техникийн туслалцаа үзүүлэх

5.2.2 Залуучуудын хөгжил, хамгаалал, аж байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

5.2.3 Зөвлөлийн хуралдаанд өөрийн хүсэлтээр оролцож, хэлэлцэх асуудлаар санал гаргах.

ЗУРГАА. ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН БАРИМТЛАХ ҮНЭТ ЗҮЙЛ

6.1 Цаашдын ахиц, хөгжлийн боломжийг олж тодорхойлон бусдадаа ойлгуулан дэмжлэгийг нь авч, тэднийг урам зоригжуулан, хамтдаа бодит үйл хэрэг болгодог.

6.2 Хөгжүүлэх, сайжруулах, асуудлыг шийдвэрлэх бүтээлч шийдэл, санал санаачилгыг байнга гаргадаг.

6.3 Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харилцааг бий болгон хамт олонтойгоо хамт ажилладаг.

6.4 Монгол Улсын хууль журмыг алхам тутамдаа дээдэлдэг, аливаад үнэнч шударга ханддаг.

ДОЛОО. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1 Зөвлөл нь 21 хүртэл сондгой тооны гишүүнтэй байх бөгөөд олон талт төлөөлөл бүхий залуучуудын төлөөллөөс бүрдэнэ.

7.1.1 Зөвлөлийн гишүүн дараах шалгуурыг хангасан байна.

7.1.2 Залуучуудын хөгжлийн асуудлаар тодорхой ойлголт, мэдлэгтэй, энэ чиглэлээр цаашид ажиллах сонирхолтой байх;

7.1.3 Залуучуудын хөгжлийн бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, залуучуудын дуу хоолой, төлөөлөл болон ажиллах чадвартай, чин хүсэл эрмэлзэлтэй байх;

7.1.4 Шалгаруулалтын хугацаанд 15-33 хүртэлх настай байх.

7.2 Зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор гарсан ажлын хэсэг сонгоно. Уг зөвлөл нь албан бус, нээлттэй гишүүнчлэлтэй, залуучуудын сайн дурын нэгдэл байна.

7.3 Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 24 сар байх бөгөөд зөвлөлийн 30-иас доошгүй хувийг шинэчлэх зарчмаар ажиллана.

7.4 Зөвлөлийн даргыг 24 сар тутамд Зөвлөлийн хурлаас нууц санал хураалтаар сонгоно.

7.5 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

7.6 Зөвлөл нь Олон нийттэй харилцах алба, Эрүүл мэнд спортын алба, Хөдөлмөр эрхлэлт, эрх зүйн алба, Боловсрол соёлын алба гэсэн 4 албатай байна.

7.7 Алба бүр зохицуулагчтай байна.

7.8 Зөвлөлд орон гарсан тохиолдолд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

7.9 Зөвлөл тайланг хагас, бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулна.

НАЙМ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР

8.1 Залуучуудын зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

8.2 Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар нь Зөвлөлийн хурлын товыг 5-аас доошгүй хоногийн өмнө товлож мэдээлнэ.

8.3 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, гишүүдийг мэдээллээр хангана.

8.4 Зөвлөл улиралд хоёроос доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ээлжит бус хурлыг гишүүдийн олонхийн санаачилгаар зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

8.5 Зөвлөлийн хурлаас гарах зөвлөмжийг гишүүдийн нэгдмэл саналыг үндэслэх зарчим баримтлах бөгөөд гишүүд нэгдмэл саналд хүрэхгүй тохиолдолд хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй гишүүдийн саналаар шийдвэрлэнэ.

8.6 Зөвлөлийн зөвлөмж нь санал, дүгнэлт хэлбэртэй байж болно. Зөвлөмжид зөвлөлийн дарга, хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

8.7 Зөвлөлийн үйл ажиллагаа, хурлын тэмдэглэл, шийдвэрийг сүлжээгээр гишүүдэд цахим хэлбэрээр мэдээлэх бөгөөд олон нийтэд нээлттэй байна.

8.8 Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй тохиолдолд хурал зарласан өдрөөс хоёроос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудлын талаарх саналаа хурал болохын өмнө зөвлөлийн дарга болон нарийн бичгийн даргад цахим шуудангаар хүргүүлнэ.

8.9 Хурал бүрт өмнөх хурлаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийн талаар зөвлөлийн нарийн бичгийн дарга мэдээлэл бэлтгэн танилцуулж, гишүүн тус бүр саналаа 5 минутад багтаан хэлэлцүүлж болно.

ЕС. ГИШҮҮДЭД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

9.1 Зөвлөлийн нэр хүнд, эрх ашгийг хөндсөн дараах нөхцөлд гишүүдэд хариуцлага хүлээлгэх үндэс болно.

9.1.1 Зөвлөлийн журмыг удаа дараа зөрчсөн

9.1.2 Зөвлөлийн хуралдааныг дараалан 3 удаа тасласан

9.1.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүй удаа дараа хоцрох

9.1.4 Зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үл хүндэтгэх, эсрэг мэдэгдэл хийх

9.1.5 Зөвлөлийн хуралдаан, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэхгүй байх

9.2 Гишүүдэд хариуцлага хүлээлгэх үндэслэл бий болсон тохиолдолд дараах арга хэмжээг авна.

9.2.1 Зөвлөлийн дарга тухайн гишүүнтэй уулзаж, сануулга өгөх

9.2.2 Зөвлөлийн хуралдаанаар тухайн гишүүний асуудлыг авч хэлэлцэн сануулга өгөх

9.2.3 Зөвлөлийн хуралдаанд гишүүний оролцсон байдал, хийсэн ажлын талаар хэлэлцэж зөвлөлийн бүрэлдэхүүнээс хасах

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

10.1 Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг зөвлөлийн гишүүдийн олонхийн санаачилгаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор хэлэлцэн баталгаажуулна.